

Дэлгэрэнгүй мэдээлэл авах эх сурвалж :
Менежер : Б.Зоригоо
Холбоо барих утас : 80409310
Цахим шуудан : info@childfood.ub.gov.mn

“ӨСВӨР ҮЕ ХҮНС” ОНӨААТҮГ-ЫН АЖИЛТАН, АЛБАН ХААГЧДЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025 оны 06 дугаар сарын 10

Улаанбаатар хот

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хийгдсэн ажил
1.	Ажилтнуудын ажиллах нөхцөлийг сайжруулах тав тухтай орчинг бий болгохын тулд өрөө тасалгааны агааржуулалт, чийгшүүлэлт, гэрэлтүүлэг цэвэрлэгээний чанарыг дээшлүүлэх, цэцэгжүүлэх ажлыг зохион байгуулах мөн ажилтнуудын албан хэрэгцээнд тулгуурлан бичиг хэрэгсэл, шаардлагатай бусад материал, техник хэрэгслээр хангах;	Тус байгууллагын албан контор нь эрүүл ахуйн шаардлага хангахгүй болсон тул түрээсийн шинэ байранд 2022 оны 09 сард орж ажилтнуудыг аятай тухтай ажиллах нөхцөл боломжоор хангаж ажиллаж байсан боловч, 2024 оны 10 дугаар сард түрээслэгч компани гарах мэдэгдэл өгснөөр оффисоо “Асио” захын дэргэд нүүлгэн шилжүүлж шинэ байранд орсон.. Мөн байгууллагын хашаанд хавар цэцэг тарьсан. Ажилтнуудыг бичгийн цаас, шаардлагатай бичгийн хэрэгслээр тогтмол хангаж ажиллаж байна.
	Ажилтнуудын үдийн амралтын үеэр богино хугацаанд алжаал тайлах /цай, кофе уух, хөгжим сонсох, сонин сэтгүүл унших гэх мэт/ амрах өрөө, орчинтой байх нөхцлийг бүрдүүлэх	Ажилтан албан хаагчдын хөдөлмөрлөх хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэсэн хувцас солих, түр амрах, хооллох зориулалтаар хуучин оффис байсан 2 өрөөг тохижуулж ахуйн байртай болсон.
	Үйлчилгээний болон түгээлтийн ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгсэл болон үйлчилгээнд шаардагдах хэрэгсэл, материалаар хангах;	Ажлын тусгай хувцсыг 2024 оны 12 дугаар сард хуваарийн дагуу нийт жолооч, ачигч, үйлчлэгч нарт давхардсан тоогоор 54 ширхэг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан махны, ногооны, өдөр тутмын гэсэн 3 ээлжийн ажлын хувцсыг захиалгаар хийлгүүлж, 2025 эхний хагас жилдээ хэрэглэж, ажилтны хэвийн ажиллах нөхцөлийг хангаж ажилласан. Шаардлагатай ажлын хувцсыг 2025 оны 08 дугаар сард хичээлийн жил эхлэхэд захиална. Жолооч, ачигч нарт нэг бүрийн хамгаалах хэрэгсэл болох амны хаалт, бээлийгээр өдөр тутам хангаж хэвшсэн.

		Нурууны хамгаалах, хөдөлмөрийн аюулгүй байдлыг бүрэн хангасан 2 ширхэг ширэн бүсийг шинээр ажилд орсон ачигч, жолооч нарт олгож, Хамгаалах бүсээр нийт жолооч, ачигч нар бүрэн хангагдсан.
	Үндсэн цалинг үе шаттайгаар нэмэгдүүлэх	Ажилтан албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хүрээнд 2025 онд ажилтан албан хаагчдын үндсэн цалингийн хэмжээг 20 хувиар нэмэгдүүлэхээр төлөвлөж Нийслэлийн Өмчийн харилцааны газарт хүргүүлсэн.Хариу ирээгүй байна.
	Байгууллагын ажилтнууд нь хариуцан ажиллаж буй чиг үүргийн хүрээнд мэргэжил дээшлүүлсэн тохиолдолд байгууллагын дотоод журмын дагуу тодорхой хэмжээний мөнгөн тэтгэмж олгох	4. Тус байгууллагын тооцооны нягтлан бодогч Б.Баяргэрэл, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан Г.Энхбуд, түгээлтийн нярав Г.Одонтуяа, Г.Буян-Ундрэм, О.Оюунгэрэл, Б.Батхуяг, ачигч Б.Билгүүн нар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгож, АЗ гэрчилгээ авах сургалтад 2024 оны 04 дүгээр сард суусан. Нэг хүний төлбөр болох 85,000 төгрөгийг байгууллагаас төлсөн.
2.	Уралдаан, тэмцээнд оролцож амжилт гаргасан мөн ажлын үр дүнг үнэлсний үндсэн дээр шилдэг ажилтнаар шалгарсан ажилтныг байгууллагын дотоод журмыг үндэслэн байгууллагын захирлын тушаалаар шагнаж урамшуулах	Байгууллагын дэргэдэх “Залуучуудын хөгжлийн зөвлөл”-өөс санаачилга болон ажилтнуудын саналаар 04-р сарын 24”-ний өдөр ажилтнуудын дунд “Биллиард”-ын тэмцээнийг зохион байгууллаа. Уг тэмцээнд менежер Б.Зориггоо түрүүлж, жолооч Б.Ганбаяр дэд байранд шалгарсан байна.
	Ажилтнуудын ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлэн хагас жилд нэг удаа үр дүнгийн урамшуулалт цалинг захирлын дэргэдэх зөвлөлийн хурлаас гарсан саналыг үндэслэн захирлын шийдвэрээр олгох	Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 7.3.2-д заасны дагуу 2025 онд байгууллагын үйл ажиллагаа тогтвортой, хэвийн, ашигтай ажилласан тул ажилтнуудын ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлэн 2025 оны 07 дугаар сард үр дүнгийн урамшуулалт цалинг Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэж захирлын шийдвэрээр сарын үндсэн цалингийн 100 хүртэл хувиар тооцож олгохоор төлөвлөж байна.
	Ажилтны хөдөлмөрийн амжилт, гавьяаг үнэлж төрийн шагнал, одон медалиар шагнуулах асуудлыг хөдөлмөрийн дотоод журмаар зохицуулах.	Тус байгууллагын касс аж ахуйн нярав Б.Баярмаа нь хөдөлмөрийн амжилт, хийж бүтээсэн ажлаа төр засгаар үнэлүүлж “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар шагнуулсан.

3.	Ар гэрийн гачигдал, шинээр гэр бүл болох, шинээр хүүхэдтэй болоход санхүүгийн дэмжлэг, буцалтгүй тусламж үзүүлэх	Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу шинээр байр худалдан авсан 1 ажилтанд байгууллагаас нэг сая төгрөгийн мөнгөн тэтгэмжийг олгосон.
	Албан хаагчдын 0-16 насны хүүхдүүдэд Хүүхдийн баяр, Шинэ жилийн баярыг тохиолдуулан баяр хүргэж бэлэг хүргүүлэх	Хөдөлмөрийн дотоод журмын 7.4.8-д заасны дагуу баярыг тохиолдуулан тус байгууллагын ажилтнуудын хүүхэд тус бүрд 45,000 төгрөг хүртэлх үнийн дүн бүхий бэлгийг байгууллагын зардлаар, захирлын шийдвэрээр олголоо.
	Ахмадын өдрөөр өндөр настнуудыг хүлээн авах	Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх заалт, байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын 7.4.2-т заасны дагуу цагаан сар, билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгний өдрийг тохиолдуулан тус байгууллагад ажиллаж байсан ахмад настууддаа хүндэтгэл үзүүлж, бэлэг дурсгалын зүйл гардуулсан.
	Байгууллагын нийт ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах	Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвтэй байгуулсан гэрээний дагуу урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээг 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдөр өөрийн ажлын байран дээр зохион байгуулж, одоо ажиллаж байгаа нийт 32 ажилтан, албан хаагчдыг хамруулж хяналт тавьж, бүртгэл хөтлөн ажиллалаа. Шинжилгээгээр эрүүл мэндийн үзлэгт тэнцээгүй ажилтан байхгүй.
4.	Байгалийн үзэсгэлэнт газраар аялах, танин мэдэхүйн идэвхтэй амралт зохион байгуулах;	Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлөөс санаачлан хүүхдийг соёл урлагаар дамжуулан нийгэмшүүлэх ажлын хүрээнд байгууллагын нийт хүүхэд багачууд, эцэг эхийн хамт 2025 оны 05 дугаар сарын 24-ний өдөр “Монголын үндэсний музей”-г үзэж нэг өдрийг хөгжилтэй сайхан өнгөрөөлөө. Тус музейг гэр бүлээрээ үзсэнээр Монгол нутагт хүн анх үүссэн нэн эртний үеэс эхлээд ардчилсан Монгол Улсын нэн шинэ түүхийн бүхий л цаг үеийг гэрчлэх үзмэр, эд өлгий, археологийн олдвор, түүхийн баримт, эх сурвалж, угсаатны зүй, соёлын биет болон биет бус өв дурсгал, гэрэл зураг, урлагийн бүтээл зэрэг баялаг сан хөмрөгтэй танилцаж эх орныхоо түүх, соёлоор бахархаж байлаа.
	Ажилтнуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдрыг чийрэгжүүлэх зорилгоор 7 хоногт 1 удаа спорт заланд чөлөөт тоглолт явуулж байх;	Байгууллагын залуу ажилтнуудын хүсэлтээр тэдний бие бялдрын хөгжил, эрүүл мэндийг хамгаалах, хамт олны уур амьсгалыг сайжруулах, ажиллах урам зоригийг нэмэгдүүлэх үүднээс 2025 оны 2-р сараас 5-р сарыг дуустал хугацаанд долоо хоног бүр спорт зааланд спортын олон төрлөөр хичээллэх ажлыг зохион байгууллаа.

